

## 12

МОНГОЛ УЛСЫГ БҮСЧИЛЭН ХӨГЖҮҮЛЭХЭД  
ЭРЧИМ ХҮЧ ХАНГАМЖИЙН ҮҮРЭГ РОЛЬ

## Ё.Гантоого

Монгол улсыг бүсчилэн хөгжүүлэх нийгэм, эдийн засгийн ач холбогдол Монгол орны нутаг дэвсгэрийн нөхцөл байдалд нийгэм, экологийн тэнцвэр, харилцан уялдааг хангах зайлшгүй бөгөөд энэ зорилгоор эдийн засгийг зохицуулах бодит шаардлага бидэнд тавигдаж байгаа юм. Бүс нутгийн хөгжлийг нийгэм, эдийн засаг, байгалийн нөхцөл байдалтай холбон авч үзвэл:

Өнөөгийн Монгол улсад ажилгүйдлийн түвшин, орлого, орон сууцны нөхцөл, боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, мэдээллийн үйлчилгээний хүртээмж чанар зэрэг нь хүн амын амьдралын түвшинг илэрхийлж байдаг гол үзүүлэлтүүд аймаг, хот, бүс нутгаар нилээд ялгаатай болжээ. Иймд хүн амын амьдралын түвшинг аймаг, бүс нутгуудын хөгжлийн нөөц боломж, өвөрмөц нөхцөл байдалд нь нийцүүлэн дээшлүүлэх нь Монгол улсын бүс нутгуудын хөгжлийн хувьд чухал ач холбогдолтой асуудал болж байна. Эдийн засгийн хөгжлийн ерөнхий түвшин аймаг, хот, бүс нутгаар ихээхэн ялгаатай байгааг нэг хүнд ногдох ДНБ-ний ялгаанаас харж болох юм.

Баруун бүсийн нэг хүнд ногдох ДНБ Улаанбаатар хотын энэ үзүүлэлтээс 3.6 дахин бага, Хангай бүсийн энэ үзүүлэлтээс 1.78 дахин бага, улсын дундажаас 2.2 дахин бага байна. Зүүн бүсийн нэг хүнд ногдох ДНБ Баруун бүсийн энэ үзүүлэлтээс 1.4 дахин их байгаа ч улсын дундажаас 1.5 дахин бага байна. Үүнээс үзэхэд аймаг хот, бүс нутгуудын эдийн засгийн хөгжлийг дээшлүүлэх явдал бүсүүдийн хувьд чухал ач холбогдолтой юм.

Өнөөгийн Монгол улсад нийгмийн хөгжлийн хүрээнд ч, эдийн засгийн хөгжлийн хүрээнд ч аймаг, хот, бүс нутгууд хооронд ихээхэн ялгаатай байна гэж хэлж болно.

Аймаг, хот, бүс нутгуудын хэмжээнд байгалын нөөц баялгийн зохистой ашиглах, хамгаалах ажлыг сайжруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах асуудал чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Энэхүү зорилгын хүрээнд үндэсний болон бүс нутгийн нийтлэг ач холбогдол

бүхий бүсүүдийн хооронд нь болон гадаад зах зээлтэй зохистой холбож чадахуйц суурь салбарын(дэд бүтэц) сүлжээг бүрдүүлэх нь гол зорилтуудын нэг болж байгаа билээ.

Суурь салбарын бүрэлдэхүүн хэсгийн нэг болох эрчим хүчний найдвартай, тогвортой хангамж буй болгох явдал юм. Өнөөгийн байдлаар дээрх чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, түүний үнэлэмжийг тодорхойлох асуудал манай улсын хувьд төдийлөн судлагдаагүй байна.

2. Бүс нутаг болон хөдөө орон нутгийн эрчим хүчий хангамжийн зарим асуудлууд

Эрчим хүчний хангамжийн байдал ч аймаг, хот, бүс нутгуудаар багагүй ялгаатай байна. Сумын төвийг цахилгаан, дулаанаар найдвартай хангах явдал хөдөөгийн хөдөлмөрчдийн, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чухал хүчин зүйл болдог.

Бүс нутгийн цахилгаан хангамж, хэтийн төсөвийн асуудалд уламжлалт соёл, өргөн уудам нутагт тархан байрласан хөдөөгийн хүн ам, эрс тэс уур амьсгал, байгалийн нөөц баялаг хүрээлэн байгаа орчны олон онцлогийг авч үзэх хэрэгтэй болно.

Бүх сумын төв, суурин газрыг 3 гол бүлэгт ангилан дараах хүснэгтэд үзүүлэв.

Оршин суугчдын тооны ангилал	A	B	C	Нийт
	бүлэг (1000 хүртэл хүн амтай)	бүлэг (2000-аас дээш хүн амтай)	бүлэг (4000-аас дээш хүн амтай)	
Сум суурингийн тоо	156	130	36	322
Эрчим хүчний системд холбогдсон	50	61	25	136
Эрчим хүчний системд холбогдоогүй	106	69	11	186

Сумдын төв, суурин газруудын цахилгаан хангамжийн шийдлээр нь ангилан үзвэл:

Цахилгаанжуулалт	Сүлжээнд холбогдсон	Сүлжээнд холбохоор шийдвэр гарсан	Системд холбохоор санал болгосон	Бие даасан цахилгаан хангамжтай байх
Сумын төв	126	39	32	103
Суурин газар	19	1	2	-
Нийт	145	40	34	103

### 3. Эрчим хүчний хэтийн хөгжлийн системт шинжилгээний чиг хандлага

Энэ системийн хандлагын аргын гол агуулга нь эрчим хүчний нөөцөөс авахуулан эрчим хүчний эцсийн хэрэглэгчид хүртэлх нэгдмэл зүйл гэж үздэг.

**Аж үйлдвэржсэн орнуудад** эрчим хүч нь эдийн засгийн бие даасан байдалд нөлөөлөх ба гадаад бодлого, эдийн засгийн салбарын хөгжлийг хангах, байгаль орчны нөлөөлөл г.м. асуудлыг хамарч байдгийг судласан байх юм.

**Барууны орнуудад** эрчим хүчний урт хугацааны системийн шинжилгээний практик туршлага ба судалгааны олон арга байгаа юм. Эрчим хүчинд шинжлэх ухаан техникийн талаарх олон улсын мэдээллийг судлан хэрэглэх, шинжилгээ хийх тэрчлэн шинэ төрлийн төхөөрөмж, процессын үндсэн тодорхойломжийг системчлэх арга хэмжээ авч байна.

Дээрх улс орнуудын туршлагыг өөрийн орны өвөрц болон экологийн байдлыг харгалзан бүс нутгийн цахилгаан хангамжийн шинжлэх ухааны үндэслэлтэй загвар боловсруулах хэрэгтэй гэж үзэж байна.

#### Дүгнэлт:

1. Илтгэлийг бүхэлд дүгнэж үзвээс бүс нутгуудын эрчим хүчний микро бүтцийг эхний ээлжинд бий болгох ёстой хийгээд энэ чиглэлээр өөрийн орны бүс нутгийн эдийн засгийн хөгжилтэй уялдсан судалгааг хийх шаардлагатай байна.

2. Бүс нутгийн эрчим хүч хангамжийн судалгааны үндсэн дээр буюу тухайн бүсийн хөгжлийн тааламжтай болон тааламжгүй байдлыг харгалзсан бүс нутгийн эрчим хүчний хөгжлийн загварыг гаргаж тавих хэрэгтэй байна.